

“ЭЕШ-ийн сэдэв, даалгаврын тогтолцоо” төсөл

Төслийн үндэслэл

Улс орны хөгжил боловсролтой боловсон хүчний чадавхиар хэмжигддэг билээ. Боловсролтой хүнийг бий болгохын тулд чанартай боловсролыг системтэйгээр өгөх хэрэгтэй юм. Ингэхдээ боловсролын чанарыг бодитойгоор үнэлэх, цаашлаад үнэлж буй сэдэв, даалгавар нь стандарт шаардлагыг хангасан байх ёстой байдаг.

Ихэнх улс орнуудын боловсролын үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь үнэлгээний сэдэв, даалгавруудад тодорхой шалгуурыг тогтоон стандарт гаргасан байдаг байна. Уг стандартынхаа хүрээнд сэдэв, даалгавруудаа зохион, үнэлж, үр дүнгийн боловсруулалт хийдэг байна.

БСШУЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь бүх шатны боловсролын үйлчилгээний чанарт үнэлгээ өгөх үндсэн үүрэгтэй бөгөөд одоогийн байдлаар элсэлтийн ерөнхий шалгалт, бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Үнэлгээ хийх эх сурвалж болох шалгалт, судалгааны материалыг боловсруулахдаа багш, судлаач, шинжээчээс бүрдсэн баг, хүнийг дайчлах замаар боловсролын үнэлгээний дүнг гаргах, олон нийтэд мэдээллийг түгээх ажлуудыг зохион байгуулдаг.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг манай байгууллага 5 дахь жилдээ зохион байгуулж байна. Уг шалгалтыг зохион байгуулахад орчин үеийн техник, технологийн дэвшлийг өргөн ашигладаг бөгөөд шалгалтын сэдэв, даалгаврын боловсруулалт, үр дүнгийн боловсруулалт хийхдээ ч мөн хэрэглэдэг. Үнэлгээ хийхэд сэдэв, даалгаврын чанар нь шалгалтын чухал асуудлын нэг билээ. ЭЕШ-ын шалгалтын 10 чиглэлээр сэдэв, даалгаварт тодорхой шалгуурыг тавин удирамжийн дагуу мэргэжлийн өндөр чадвартай багш нарыг дайчилдаг ч цаг хугацаа, хөрөнгө хүч ихээхэн зарцуулсан, нууцлал болон үр дүнд зарим алдаа үүсэж болох эрсдэлийг бас өөртөө агуулж байдаг талтай.

Гэхдээ шинэчлэлийг үе шаттайгаар хийхээр төлөвлөн сэдэв, даалгаврын боловсруулалт, үр дүнгийн анализ, шинжилгээний үндсэн дээр даалгаварт тавигдах шаардлага, стандартыг боловсруулан шалгалтын материал, суралцагчдын алдаа, оноон дээр шинжилгээ хийх замаар дараа, дараагийн сэдэв, төслийн боловсруулалтыг боловсронгуй болгох, сургалтын бодлогод түүнийг харгалзах асуудлыг сайжруулах хэрэгтэй байна. Иймд Боловсролын хүрээлэн зэрэг мэргэжлийн байгууллагатай энэхүү төслийг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Төслийн зорилго

Төслийн зорилго нь ЭЕШ-ын 2009 оны сэдэв, даалгавруудын гүйцэтгэлд шинжилгээ хийх, шалгалтын сэдэв, даалгаврын стандарт боловсруулах

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- V. 2009 оны ЭЕШ-ын сэдэв, даалгавруудын гүйцэтгэлд шинжилгээ хийх
- VI. Хичээл бүрээр даалгаврын шинжилгээ боловсруулан үр дүнгийн боловсруулалт хийх
- VII. ЭЕШ-ын сэдэв, даалгаврын стандарт боловсруулах

Төслөөс гарах үр дүн

- Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ.
- 2009 оны ЭЕШ-ын сэдэв, даалгавруудыг шинжилсэн байх
 - ЭЕШ-ын хичээл тус бүрийн агуулгын хүрээг тодорхойлсон байх
 - ЭЕШ-ын сэдэв, даалгаврын стандарт боловсруулсан байх
 - ЭЕШ-2010-ын хичээл тус бүрийн блюпринт тодорхойлогдсон байх
 - Шалгалтын сэдэв зохиох багийн гишүүдэд гарын авлага гарсан байх
 - Суралцагчдын нийтлэг алдааг харгалзан сургалтын агуулга, бодлогод засвар оруулах зөвлөмж боловсруулсан байх